

**ХАНХОНГОР СУМЫН ТҮҮХТ ЗУУН ЖИЛИЙН ОЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ
БУЙ “ОРОН НУТГИЙН ӨНГӨ ҮЗЭМЖ, АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН”
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

Хэлэлцүүлгээр хэлэлцэх асуудал:

- Сумын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулъя
- 2024 оны сумын төв дээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил
- Санал хүсэлт, асуулт

2024 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр соёлын төвд 15:20 цагт хэлэлцүүлэг эхэллээ. Хөтлөгч Ц.Мөнхдалай.

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн та бүхэндээ айлчлан мэндчилье. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Сайнбуян даргын санаачилсан “орон нутгийн өнгө үзэмж, амьдрах таатай орчин” хэлэлцүүлэг эхлэх гэж байна. Ингээд та бүхэндээ хэлэлцүүлгийн журмыг танилцуулъя.

- Хэлэлцүүлгийн журмыг уншиж танилцуулав. /Дэгийг танилцуулав/
- Хөтөлбөрийг уншиж танилцуулав.

Хэлэлцүүлэгч талын эрхмүүдээ урьж байна. ИТХ-ын дарга Г.Сайнбуян, Засаг даргын орлогч Б.Нямдорж. Албан ёсоор нээж өгнө үү гээд хэлэлцүүлэгч талд микрофон оо шилжүүлье.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Сайн байцгаана уу? Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Юуны түрүүнд урилга хүлээн авч хүрэлцэн ирсэн сумын уугуул суугуул иргэддээ талархсан сэтгэлээ илэрхийлье. Хэлэлцүүлгийн бэлтгэл хангаж ажилласан ИТХ-ын ажлын алба, соёлын төвд баярлалаа. Зохион байгуулагч талаас сая маш тодорхой тайлбарлалаа. Хурал, цуглаан биш. Зорилгыг бас зохион байгуулагч танилцууллаа. Тодруулбал:

1. 100 жилийн ойгоор олон хүмүүс ирж 3-4 хоног байрлаж бидний амьдралын орчныг нүдээрээ харна. Үе үеэрээ дамжин залгамжилж ирсэн сумынхаа 100 жилийн ойгоор ямар байлгах нь та биднээс л хамаарна. Тийм учраас орчин тойрондоо ач холбогдол өгөх нь зөв.

2. 100 жилийн ойг угтаж хийсэн ажил маань 100 жил дуусахад хийсээд явчихааргүй. Мөн өнөөдрийн хэлэлцүүлгээр гарсан шийдвэр амьдралын чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байх гэсэн ийм 2 талтай.

Өмнө нь хэлж байсандаа. Тэгшлэх, янзлах, өөрчлөх газар юу байна? өөриймсөг харж ирээрэй гээд. Би өмнө олон ч наадмын зохион байгуулалтад оролцож байсан. 90 жилийн ойгоор манай нэг ах “гүй ээ та нар чинь сумын чинь 90 жилийн ой болж байхад сумандаа юм хийсэн юм уу?” гэж билээ. Тухайн үед надад хэлэх ч үг

олдоогүй. Энд бид хэлэлцсэн асуудлынхаа шийдлийг олох хэрэгтэй. Үүнийг тэгчих юм сан, түүнийг ингэчих юм сан гэсэн бодол байдаг бол санал аа хэлээд яваарай. Бид нар урагшаа харж явах ёстой учраас нэгнийгээ загнахгүй, зэмлэхгүй. Бидний энэ хэлэлцүүлэг үр дүнгээ өгч 100 жилийн ойгоороо бүгд гялалзаж байхын ерөөл өргөө.

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Заа баярлалаа. Газрын даамал Б.Уянгыг урьж байна.

Б.Уянга – Газрын даамал: Сайн байцгаана уу? Сумын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулъя. Эдгээр ажлууд бүгд тендер зарлагдаад явж байгаа ажлууд шүү. /Дэлгэцээр танилцуулав/

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Хэлэлцэх асуудлын дараалал ёсоор танилцуулга явлаа. Асуух асуулттай хүн байвал гараа өргөөд асууж болно шүү. Үүнийг тэгмээр байна, ингэмээр байна, ямар өнгөөр будах юм гээд сонирхсон асуултаа санаа зоволтгүй асуугаарай. Заа байхгүй бол дараагийн танилцуулга 2024 оны сумын төв дээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил танилцуулагдах нь ээ. Засаг даргын орлогч Б.Нямдорж танилцуулна.

Б.Нямдорж – Засаг даргын орлогч: Сайн байцгаана уу? Хүрэлцэн ирсэн нийт ард иргэддээ баярлалаа. 2024 оны сумын төв дээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг танилцуулъя. /Дэлгэцээр танилцуулав/

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Засаг даргын орлогч, газрын даамал хоёртоо баярлалаа. Одоо удирдамжийн дагуу танилцуулах ажил болсон. Газрын даамал танилцуулсан гэрэлтүүлгүүд, хашаа, хаяг гоё болох юм байна. Төрийн зүгээс хийгдэх ажил ингээд болчхож байгаа гэдгийг ойлгож байгаа байх. Одоо үлдсэнийг нь яах вэ? Өөрсдийн хашаа, нийтийн гудамж, талбай зэргийг яах аа ярилцаад явна.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Нэмэлт мэдээлэл хийж болох уу?

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Сэдэвтэй холбоотой бол болно.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Холбоотой. Сайн байцгаана уу? Оройн мэнд. Танилцуулгуудыг ойлгосон байх. Би нэмэлтээр ганц нэг юм хэлэх гээд. /Нэмэлт танилцуулга хийлээ/

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Заа. Компьютер холбогдтол, зураг гарч иртэл эхний санал гаргах хүн байна уу?

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Хэлэлцүүлгийн дарааллаар эхний 2 мэдээлэл танилцуулагдлаа. /Гурвансайхан сумын хөгжлийг судалсан туршлагаас хуваалцав/ Иргэдийнхээ санал, санаачилгыг сонссон гэж тайлбарлаж байсан. Санал аа хэлэх хүн байна уу? Мөн цаасаар санал аа өгч болох байгаа шүү.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Би цайз захас хашааны үнэ өртгийг судалсан. /Уншиж танилцуулав/ Аймагт зарагдаж байгаа үнийг бодвол харьцангуй хямд үнэтэй байна. Банзыг бол худалдаж авч өгнө гэж байхгүй. Ямар боломж бололцоо байгааг ярилцана. Одоо хэлэлцүүлгийн гол үе рүү орно. Энэ хашаануудыг яах юм?, Элка тэр дээр нь онгойсон барилга аа яах юм?, Бор даргын хашааны урд хэдэн шошиг яах

юм?, намын байр яах юм?. Заа Өгөөмөр хорооллынхон энэ зургаас хашаагаа нэг хараадах. Эмнэлгийнхэн,, эмнэлгийн арын нойл байгаа юу?

Ц.Батбэх – БОУБайцаагч: Байгаа. Ашигладаг 2 айл байгаа.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Өлзийтийн энэ булангууд тэгширнэ гэсэн. Баян хорооллын энэ нүүрний эгнээний хоосон зай, нойлыг яана аа? Сумын төвийн маань ерөнхий байдал нэг иймэрхүү. Одоо санал аа ярилцъя.

З.Ганболд – Сургуулийн захирал: Манай хорооллын зургийг гаргаад өгөөч. Зураг гарч байх хооронд хүрэлцэн ирсэн иргэд, зохион байгуулагчдадаа баярлалаа. Манай хорооллын хамгийн зүүн талын доголтой 4 айл чацуулаад татъя гэж бид ярилцсан. Манайхан бас google map ашиглаж хашаа хороогоо харж байгаарай. Сумын 100-н жилээр өгөөмөр хорооллын нүүр асуудалгүй болсон байна аа. Ихэнх айлууд цэнхэр хаалгатай учраас үлдсэн хэдхэн айл нь цэнхэр болгоё гэж ярилцсан. Бие биеийхээ өвөрт орчихсон юм шиг энэ хашаануудыг паралель болгож янзлахаар ярилцсан. Самбуу ахынх Ганто ахынхтай хашаагаа нийлүүлээд манайх ер нь цэгцэрчихнэ гэж бодож байна. Хорооллоо төлөөлөөд нэг санал хэлэх гэсэн юм. Хашааны банзны тээврийн зардлыг сумын төсвийн хөрөнгөнөөс гаргаад авчирч болох уу?

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Хөтлөгчийн зүгээс нэг санал байна. Цэцэрлэгийн хүүхдүүдийн тарах цагийг өнөөдөртөө 30 минутаар сунгаж болох уу? тэгэхгүй бол одоо цэцэрлэгийн хүүхдүүд ээ авах гээд ихэнх нь гараад явчихна байх.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Ганболд захирлын хүсэлт дээр тайлбар өгье. Энэ хорооллын баруун зүүн талаар бохирын шугам явж байгаа тул хамаагүй тэлж болохгүй. Өгөөмөр хорооллынх ах мөөгийгийн араар зүүнтээ явсан байгаа. Баян хорооллын бохирын шугам хаагуур явж байгаа билээ Уянга заагаад өгөөрэй.

Б.Уянга – Газрын даамал: Энэ харагдаж байгаа зурган дээрх наад талын өнцгөөс урдаас хойшоо, Баяр-Эрдэнэ ахын ард талаар, Одбаяр ахын ардуур 3 шугам явж байгаа.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Мөн суулт өгсөн шугамын овгор шороог цэгцэлж өгнө өө.

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Цэцэрлэгийн хүүхэд 5:30 цагт тарахаар болсон шүү.

Х.Одбаяр – ЕБС-ын багш: Манай эгнээ их эвгүй. Батмөнх ахынхтай тэгшлээд мөн мэргэжилтэнтэй ярьж байгаад урд талаараа тэгшилнэ. Сумынхаа ойд өөр өөрсдийнхөө чадах юмаар манлайлж оролцоно гэж бодож байна. Хашааны хээ угалзыг миний бие хийж болно оо. Манай тэнд нэг овгор шороо байгаа ачуулмаар байна.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Өчигдөр аччихсан шүү.

Ж.Бор – Ханхонгор сумын иргэн: Надад 3, 4 санал байна. 1. Манай баруун талд хуучин нэгдлийн үеийн агуулах байсан газрыг дутуу түрээд орхисон. Чулуу ихтэй тул гараараа зөөх боломжгүй үүнийг зөөж өгөөч. 2. Манай урд болон баруун тал үнэхээр муухай тул би банз захиана гэж бодож байна. Хашааны банз авах боломжтой ч айл байгаа, боломжгүй ч айл байгаа. Иймээс тээврийн хөлсийг нь хөнгөлж өгөөч гэсэн нэг санал оруулж байна. 3. Наадмын талбайд сандал нэмэх, тэлэх, наадмын талбайн зүлэг хиймэл биш байж болохгүй юу? 4. Явган хүний зам шаардлага хангахгүй байна. Үүнийг ажил хэрэг болгох. 5. Хаан банкны ард мод тарих гээд нүх ухчихсан мод тариагүй хэвээрээ байгаа тэрийг янзлах гэсэн саналууд байна.

Г.Сайнтуяа – Ханхонгор сумын иргэн: Манай хашааны баруун тал өнгө үзэмж муу. Банз захиалгад нэгдэнэ ээ. Хөдөө аж ахуйн газраар дамжуулж үрсэлгээ захиалдаг шигээ цэцгийн үрсэлгээ захиалж засмал зам дагуу тариалах байх гэж бодож байна. Энэ ажил хийгдэхээс өмнө засмалын ажил дуусахаас өмнө бууц асгах, ногоон байгууламжид зориулсан худгийг будаж янзлах, хаягжуулах, Би ойдоо зориулаад худгийн хаяг хийе ээ. Үйлчилгээний газруудыг хаягжуулбал зүгээр байна. Өмнө нь Эндээ дарга уралдаан зарлаад айлуудын хашаа цэгцлүүлж байсан. Түүн шиг нүхэн жорлонгуудыг айлуудаар нь янзлуулах. Гол нь эхний 3 айлыг тодруулах биш 10-15 айлыг тодруулбал нийтийн оролцоо сайн байх болов уу. Суманд нэг бага оврын зуурах машин байвал зүгээр байна. Мод шонгийн нүх ухах техник, сайр бууц татах ажлыг Элка хариуцах уу? Ямар үнэ ханштай байгаа вэ? Газар хагалдаг жижиг оврын машин хаана байгаа вэ? Ашиглаж болох уу? Будаг, багс зэрэг ганц нэг барилгын материалыг аль нэг дэлгүүр байнгалан авчирч борлуулж байх санал оруулж байна. Байгууллага болгонд хог цэвэрлэх савар өөрийн зүгээс хандивлаж байна. Соёлын төв гадаа цэцгийн мандалдаа цэцэг тарихаар бол би туслаад аргагүйн зөвлөгөө өгч болно шүү. Сумынхаа логоог хэвлээд гэрлийн шон дээр наах бас борлуулах хэрэгтэй. Заа ингээд миний санал дууслаа.

Я.Гэрэлмаа – Ханхонгор сумын иргэн: Мал эмнэлгийн замыг хаалгамаар байна. Манай гэрлийн утсыг хэд хэдэн удаа тасалсан.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Сайнтуяа эгчийн хэлсэн саналууд үнэхээр гоё санал байна. Баярлалаа. Тэр замыг бол бүхэлд нь хаана гэж бол байхгүй. Бор даргын зүүнтээ байгаа чулууг ачаад морь барианы овооны суурь хийе гэсэн саналтай байна. Замын ажил дуусаагүй байгаа. Одоо гүйцээж хийнэ ээ. Ногоон байгууламжийн хувьд юу тарих аа бодож л байна. Наадмын талбайд мөн засвар хийгдэнэ ээ.

А.Саранцэцэг – Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч: Замын гарц дээр санал хэлмээр байна. Нэмэлт гарц гаргах боломжтой юу? Дэлхий тойрч байгаа юм шиг алхсаар байгаад л таарах юм.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Би түрүүхэн тайлбарласан. Та байгаагүй бололтой. Замын ажил хараахан дуусаагүй байгаа. Хаана, хаана гарц гаргахаар байна боломжоор нь нэмээд гаргуулна аа.

Т.Должин – Ахмадын хорооны дарга: Манай ахмадын өргөөний гадна талын хайс хамгаалах тор урагдаад дуусаж байгаа. Би говийн оюу-д төсөл бичиж өгсөн

боловч хариу өгөөгүй. Сумын 100 жилээр ийм хашаатай байж болохгүй. Сая өгсөн хашаа янзлах мэдээлэл дунд харагдсангүй. Манай хашаа орж байгаа юу? Хэрэв ороогүй бол нэмж өгөөч ээ. 2. Манай суманд нэг ч үйлчилгээний газар байхгүй. Ирсэн явсан хүмүүс их асуудаг тул үйлчилгээний газартай болох хэрэгтэй. 3. Ахмадын сувилал хаана баригдах вэ?

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Ахмадын сувилал мандах багт баригдана. Голын цаад тал дээр барихаар ажлын даалгавар хийгдсэн. Баазыг түшиглэж хийнэ. Ахмадын өргөөний баруун талаар бохирын шугам, доод талаар нь шахуу цэврийн шугам явж байгаа. Ямар ч байсан ойгоор ийм байдалтай байлгахгүйг хичээнэ ээ. Хуучин тамгын газар бол хувийн эзэмшлийн барилга байгаа юм аа. Эрдэнэбаяр даргынх.

У.Эрдэнэбаяр – Мандах багийн Засаг дарга: Хувьчлалаар надад ирсэн юм байгаа юм аа. Ойгоос өмнө оролдох санаатай байгаа. Ямар ч байсан хүн харахаар болгоно оо.

Б.Нямдорж – Засаг даргын орлогч: Ахуй үйлчилгээний төв байгуулахыг судалж байгаа. Залуучууд хөгжлийн төв, фитнес өрөө, нийтийн нойл, ахуй үйлчилгээний тасалгаа зэргийг залуучууд хөгжлийн төвдөө төлөвлөөд зураг төслийн үе дээрээ явж байгаа шүү.

Б.Сугир – Удмын өргөө хоршооны дарга: Үйлдвэрийнхээ өнгө үзэмжийг сайжруулах, шинэчлэх тал дээр хичээж ажиллана аа. Сумын төв дээрээ нүүж ирээд үйлдвэрээ ажиллуулахаар төлөвлөж байгаа. Сумынхаа ойд хамтарч ажиллахад бэлэн байна.

Д.Чингэсмаа – Ханхонгор сумын иргэн: 1. Засмал зам руу гарах буух явган хүний гарц гаргах. 2. Мөнжиг манай хоёрын арын шонг сольж өгнө гэсэн ажил хэзээ хийгдэх вэ?

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Замын ажил дуусаагүй байгаа гэж зөндөө хэлж байна даа. Боломж бололцоогоороо гарц гаргана. Шон хүрэлцэхгүй байсан тул хамгийн гайгүй 3 шон үлдээсэн. Улс төр болгож ярих аа одоо болимоор юм.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Хүүхдийн тоглоомын талбайнхаа баруун болон урд талд дэлгэцээр харагдаж байгаа шиг хашаа хийнэ. Миний тооцоолсноор 4 сая орчим төгрөг хэрэг болно. Манайх дэлгүүрийн хойно байрлалтай хөл хөдөлгөөн ихтэй учраас хаашаагаа гоёх нь зөв. Байшингийнхаа баруун талын сүүдрэвчийг авч тэр орчмыг талбайжуулна. Зөрсөн хашаануудыг тэгшилж хаалга үүд хийнэ гэж төлөвлөсөн байгаа.

Ц.Батбэх – БОУБайцаагч: Оройн мэнд. Газар хашаа тэлнэ гэж яригдаад байх юм. Кадастрынхаа дагуу байгаа юу? Дарга удирдлагууд үүнийг анхаарч байгаа юу? Нэг айл хашаагаа тэлээд тэгшилчихэд бусад айл нь дагна шүү дээ. Газрын тухай хуулиараа болох зүйл үү? 2. Хашааны банзны тээврийн зардлыг хөнгөлөөд хотын үнээр бидэнд нийлүүлнэ гэсэн үнэн үү?

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Газар томорсон, тэлсэн бол хуулиараа төлбөр төлөх шаардлагатай. Хэрэв тэгэхгүй бол гэрчилгээ гарах боломжгүй болно. Тээврийн зардлын хувьд ярилцаад д байна. дүнгийн хурал дээр танилцуулна аа.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Баянмөнхийнх хашаагаа яах гэж байна. Яг ард талаар нь наадамчид явах байх. Өнөрөө эгчийнх хашаагаа будаад зосдоод болчих байх. Үүнийг одоо яах уу буулгах уу? Элкагаас хүн байна уу?

Ц.Отгонбаяр – Элка ОНӨААТҮГ-ын нягтлан: Буулгана.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Буулгах барилгыг эртхэн буулгахгүй бол газар эдгэх гэж хугацаа орно шүү. Гүндмаа эгчийнх хашаажих уу яах уу? Хүн очиж буух уу? Энэ 2 нойлыг яах юм?

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Өөр санал санаачилгатай хүмүүс газрын даамал дээр очиж ярьж хэлж байх хэрэгтэй.

Л.Мөнхбаяр – Сургуулийн харуул: Манайх баруун хойд талдаа доголтой мөн яг зам дээр. Хашаагаа түгжих гэхээр зам хаачих гээд түгжихгүй байх хэцүү. Яах аа мэдэхгүй гайхаад л байна. Хашаагаа түгж гэвэл түгжинэ ээ.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Өөрийн өмчлөлд байгаа газраа түгжих нь таны эрх шүү.

Л.Мөнхбаяр – Сургуулийн харуул: Хашаагаа түгжихээр Элка руу орох газаргүй болох гээд.

З.Ганболд – Сургуулийн захирал: Хашаагаа жаахан сунгаад нөхчхөж болох уу? 0,07 доо хүрдэггүй. Кадастр нь бол Магнай ахынхтай бараг тулдаг.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Ерөнхий төлөвлөгөө дэлгэцэн дээр гаргаад ирээрэй. Энэ төлөвлөгөөнд өлзийт хороолол хашаагүй байхаар хийгдсэн байгаа.

З.Ганболд – Сургуулийн захирал: Миний бас бодож явдаг л зүйл байна. Аймгийн баянбулаг хороолол шиг нийтийн эзэмшлийн зам талбайтай болоход надад татгалзах зүйл байхгүй ээ.

Б.Батбаатар – Засаг дарга: Иймэрхүү нийтийг хамарсан хэлэлцүүлэг хийгдэж байхад хүмүүс идэвхтэй оролцож байх хэрэгтэй. Санал санаачилгаа хэлж байх нь зөв. Хашаагүй айл хэчнээн байна? Хашаагаа янзлах айл хэр олон байна судалж байгаад бид тээврийн зардлыг нь хөнгөлөхөөр шийдэлд хүрлээ. 2. Хашаа будах, хээлэх, гарниз татах ажлаар зураг төсөв хийлгэсэн. 40 сая орчим төгрөгийн зураг төсөв хийгдсэн байсан. Үүнийг бол төсвөөс шийдэх боломжгүй. Бааз болон уурхайд санал тавьж үзнэ ээ. 3. Эко нойл 20 ширхгийг барья гэсэн чинь иргэд маань нээх сонирхохгүй байсан. Уг нь их хэрэгтэй, үр дүн өгөхүйц ажил байсан. Ганзориг товчхон мэдээлэл өгөх үү?

Ганзориг – Даланзадгад сумын иргэн: Мэдээлэл хийлээ.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Хүн нэлээд сийрсэн байна. 18:00 цаг болж байна. Одоо жаахан базаж явах хэрэгтэй.

З.Ганболд – Сургуулийн захирал: Эко нойл их ашигтай гэж ойлгосон. Би хорооллынхоо айлд санал тавьж дэмжсэн. Ашигтай эд шүү. Манайхан бас зөв ойлгох хэрэгтэй.

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Цаасаар 2 асуулт, санал ирсэн байна. 1. Эмийн сангийн хаягжилт байгаа юу? Оруулж өгөөч гэсэн байна. 2. Хуучин уурын зуух яах вэ гэсэн байна.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Байхгүй. Хуучин уурын зуухыг засаад гарааш болгож ашиглана. Орчны хар шороон дээр сайр асгана.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Хашаа байшингуудыг бүгд ойлгосон байх. Өөрсдийн гэрэл цахилгааны аюулгүй байдлыг хангах, гадна гэрэлтүүлэгтэй айл маш цөөхөн байдаг. Үүнийг анхаараарай. Хүүхдийн аюулгүй орчин, тухтай байдал дээр хүн дугарав уу? хүүхдийн тав тухтай орчин, аюулгүй байдал энд орох ёстой. Овоолсон шороо, ариун цэвэр, нойлын асуудал болчих байх. Хог хаягдал олигтой яригдсангүй дээ. Хогийн савнуудыг будах юм уу? Бага зэрэг зайтай байвал яадаг юм? Ногоон байгууламж бас яригдсангүй дээ. Моторын байшингийн асуудал болсон, удмын өргөө болсон. Халуун усны зүүн талд сангийн шавар байгаа юу? Тэрийг одоо холдуулъя аа. Элка орчныхоо хогийг жин тан цэвэрлэх дээр анхаараарай. Мал эмнэлгийн орчин гэж сүрхий газар байна. Цаашид хэдүүлээ энэ мэтээр сумынхаа асуудлыг ярилцаж нийтийн дүрмээр амьдрах. Хашааны банзны тооцоо судалгаа хэрэгтэй. Улаанбаатарын үнээр татаж өгөхөөр болсон. Өөр асуудал хэлэлцүүлэх хүн байна уу?

Б.Нямдорж – Засаг даргын орлогч: Буян даргын хэлсэнд бидний яриагүй асуудлууд гарч байна. Аливаа асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж иргэд идэвхтэй оролцож байх хэрэгтэй. Байгууллагууд камержуулах асуудлыг хөндөөд шийдвэрлэх талаас нь яваач ээ. Аливаа асуудлаас урьдчилан сэргийлэх үүднээс шаардлагатай асуудал шүү. Хүүхдийн орчин дээр анхаарах хэрэгтэй байна шүү.

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Иргэний хувиар Элкагаас асуух нэг асуулт байна. Сумын хойд ус түгээх худаг ашиглахгүй байгаа юу? Өгөөмөр хороололд усаа тэргээр авдаг айл байгаа. Настай хүмүүс зайлуул тэрэг ээ түрээд зам гараад тэртээ холоос авч байгаа харагддаг. Өгөөмөр хорооллын тэр худгийг ашиглалтад оруулчих юм бол тэр хүмүүс гэрийнхээ гаднаас шахуу усаа авах боломжтой болно. Тэр худгийг янзлах боломж байна уу? Янзлаад өгөөч ээ.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Тэр ер нь яасан худаг юм. Өмнө нь зүгээр ажилладаг байсан биз дээ.

П.Батсайхан – Ханхонгор сумын иргэн: 2 хүний буруугаас болоод шугамын хаалт нь эвдэрчихсэн. Шугамыг нь сольчих юм бол болно оо. Тэгээд бас тэнд ажиллах хүн хүчгүй байгаа тул цахим болгочих юм бол хэвийн ажиллаж болно оо.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Тэрийг янзлаад өгчих л дөө. Яг янзлах юм уу, үгүй юм уу? хэл.

Б.Батбаатар – Засаг дарга: Иймэрхүү асуудлаа ОНХСангийн санал асуулгад оруулаад явах хэрэгтэй. Заа ямар ч байсан би анхааралдаа авлаа. Цахим болгоход 15 сая төгрөг болох юм байна. Аймагт бас тодотгол дээр хүсэлт тавиад явж байгаа. Шийднэ ээ.

А.Болормаа – Соёлын төвийн номын санч: Манай хорооллын урд хүүхдийн талбайд хүүхдүүд их тоглодог. Яг хойгуураа машины зам явдаг тул их аюултай. Хүүхдүүд гэр лүүгээ орж гарахдаа зам хөндлөн гарч гүйлддэг. Энэ тоглоомын талбайг ядаж хашаажуулаад өгөх боломж байна уу?

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Хашаатай хашаагүй хүүхдүүд гэр лүүгээ орохдоо зам гарна. Оронд нь замыг нь хаах.

М.Баярсайхан – Тамгын газрын дарга: Нийтийн эзэмшлийн гудамж талбай хаана гэж байхгүй.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: Энэ тэмдэг яагаад дотор нь байгаа юм. Замын 2 талд байх ёстой шүү дээ.

Б.Чулуундорж – Ханхонгор сумын иргэн: Тэмдэг ч байдаггүй байсан. Би захиалж авчирч байсан.

Г.Сайнбуян – ИТХ-ын дарга: /Жишээ болгон зураг үзүүлэв/ Нийтийн дүрмээр явахгүй өөрийн эрхээр явбал ийм л булай юм болно. Энэ зургийг харж байна уу? Ийм болохгүйн төлөө бүгдээрээ мэрийж ажиллах нь. Яригдаагүй үлдсэн асуудал байгаа бол сумын удирдлагадаа ярьж хэлж байгаарай. Өгөөмөр хорооллын худаг, хүүхдийн тоглоомын талбай тэмдэгжүүлэх ажлаа яаралтай зохицуулаарай.

Ц.Батболд – Ханхонгор сумын иргэн: Хашаануудаа бүгд зосдох юм уу? Будаг болох уу?

Б.Батбаатар – Засаг дарга: Өөрсдөө хашаагаа будаж болно шүү. Ер нь нийтийн жишиг л яригдаж байгаа юм. Банзны захиалгаа сайтар судалж тооцоод Тамгын газрын даргад өгөөрэй.


М.Баярсайхан – Тамгын газрын дарга: 4 сардаа багтааж өгөөрэй хүмүүс ээ.

З.Ганболд – Сургуулийн захирал: Ер нь бол хашааг 2 эмжихээр илүү насжилттай бат бөх болдог доо.

Ц.Мөнхдалай – ИТХ-ын нарийн бичгийн дарга: Заа ингээд ИТХ-ын даргын санаачилгаар ИТХ-аас зохион байгуулсан хэлэлцүүлэгт маань идэвхтэй оролцсон оролцогч талынхандаа баярлалаа. Ямар ч байсан хэдүүлээ шийдэлд хүрлээ. Үр дүнтэй хэлэлцүүлэг боллоо гэж бодож байна. Дараа дараагийн хэлэлцүүлэгтээ идэвхтэй оролцоорой.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН



Д.УЯНГА

ХАНХОНГОР СУМЫН ТҮҮХТ ЗУУН ЖИЛИЙН ОЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ
 "ОРОН НУТГИЙН ӨНГӨ ҮЗЭМЖ, АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН" ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ИРЦ

№	ОВОГ НЭР	ЭРХЭЛЖ БУЙ АЖИЛ	УТАС
1	Баатарын Нэгжүрэн	Тамварын үеийн байрвэл	89856060
2	Ц. Батбэх	БОХУБАГЦААГЧ	86052513
3	О. Амгаль	ЕБС - биологийн багш	89747472
4	Т. Алтантүвшин	ЭБС багш	89747482
5	Х. Огдвал	Урлагийн багш	88219346
6	Э. Нэгжүрэн	МАЭЗУЗ - багш	88652801
7	Д. Гангалсого	Эсгийний үйлдвэр	88530414
8	Б. Сүхрэг	- x -	89980411
9	Т. Мөнхбаяр	ЕБС	99688525
10	Н. Насантөгстөх	ЕБС	95281048
11	Д. Пунгалал	ЕБС	88613071
12	Р. Танхуял	Цахуурч	88988612
13	А. Намбаев	ЕБС	88813025
14	Д. Мөнхтүвшин	ЕБС багш	89365588
15	Д. Балрсайхан	ЕБС багш	88641906
16	Ц. Нарангарав	Д/Багшын багш	88997119
17	Д. Бүтээгч	ЕБС-ийн багш	86291055
18	Б. Тогтоол	ЕБС-ийн багш	89915951
19	Л. Бэлдэвч	ЕБС-ийн багш	90669008
20	Н. Батболд	ЕБС - н хичээл	89365588
21	Ц. Аюул-Очир	ЕБС-ийн багш	98114503
22	Б. Тогтоол	ЕБС-ийн багш	86224236
23	У. Пунгалал	АМ сувилал	88020316
24	Б. Нэгжүрэн	ЕБС-ийн багш	88487946
25	О. Энхтөгс	ЕБС-ийн багш	98113402
26	Б. Мунгалал	ЕБС сурагчдын менежер	98007887
27	Н. Доржпалсан	ЕБС багш	88006115
28	Батсайхан	ЭМКА - менежер	86715271
29	С. Номтой	ЕБС - багш	88313478
30	С. Сэргэлэн	ЕБС-ийн багш	99480383
31	С. Гантүвшин	ЕБС-ийн багш	85300572

32	Г. Урианс	Хаан Банк	89206698.
33	Н. Оринбурина	ЕБС Банк	88250221
34	О. Пэнмэн	ЕБС Банк	88687770
35	М. Аппангун	ЭМТ могоол	99441691
36	З. Тондонг	ЕБС захирал	80018850
37	Н. Ганзориг	Дэлгэрэх өтө ХХК	94006922.
38	Б. Занабазар	Дэлгэрэх 2но ХҮК	94112052
39	М. Оюунгарл	ЕБС Банк	88038841
40	Чойрдагнам	Төрөл байгаа (манай эвэр)	88349559
41	Б. Наран	Могоол	88606513
42	Б. С. Чувпунгун	ЗДТТГазар ТТК	88053498
43	А. Бадарцаа	Соёлын төв	86263670
44	Н. Нандин-Эрдэнэ	АТЭВ	88374096
45	Б. Хуудалзор	ЕБС	99436624
46	Ш. Норовнам	ЕБС	88645720
47	Б. Ормогун	Соёлын төв	80068265.
48	У. Мунхтуй	ЭМТ	89099662
49	Тунг - Энхтуй		88406645
20	Б. Чувпунгун	Төрийн могоол	88605228
21	Д. Хуудалзор	ЕБС могоол	88708045
22	Э. Тэрэлмаа	Е. Дундговь	89901161
23	М. ДДР	Могоол	88012499
54	Т. Мангун	ЗДТТГазар	80062502
55	Б. Намсрай	ЗДТТ	89682312
56	Б. Дундговь	ЗДТТГазар	88052411
57	Г. Сайнхуяг	онгоор на с мах	88603527
58	А. Сүхбаатар	ЗДТТ	89207215
59	Н. Могоол	ЗДТТ газар	88720395
60	Н. Наран	ЗДТТГазар	89084686
61	Б. Намсрай	ЗДТТГазар	94710364
62	У. Чувпунгун	10-р хороо	89843227
63	С. Оюунгарл	Төрийн (манай)	88901922.
64	М. Сүхбаатар	АХУ	80077507
65	Д. Чувпунгун	Могоол	88533478.

